

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн
06/152 дугаар албан бичгийн нэгдүгээр хавсралт



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2025 оны 06 дугаар сарын 12

Улаанбаатар хс

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Зарцуулсан Төсөв (мян.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2024	Зорилтот түвшин 2025	Хүрсэн түвшин (хүрээгүй бол тайлбар)	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 2. 2.1.Нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох, иргэдэд эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, зөв дадлыг хэвшүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж болон спортын барилга байгууламжийн хүртээмжийг тус тус нэмэгдүүлнэ. НХТЖҮЧ-3.5, НЗДҮАХ-2.1,7. НХТ-153, 154, 155							
Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт: 1. Нийслэлийн иргэдийг биеийн тамир, спортын дасгал хөдөлгөө-нөөр тогтмол хичээллэх боломжийг бүрдүүлж, бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын түвшний суурь үзүүлэлтийг 5 хувиар өсгөнө. НХТЖҮЧ-3.5.1, 3.5.3, НЗДҮАХ-2.1.7, НХТ-153, 154, 155, 156							
1.1.	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	99	25	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж, байгууллагын даргын 2025 оны А/23 дугаар тушаалаар баталж, үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тайлагнаахаар ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар биелэлт 70 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.	70%

1	2	3	4	5	6	7	8
1.2.	Биеийн тамир, спортын хуулийн дагуу дүүргийн хороодод орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллуулахад холбогдох баримт бичгийг боловсруулж 2026 оны төсөвт тусгуулна.	-	Хэрэгжилтийн хувь	-	100	Дүүргийн хороодод орон тооны арга зүйч ажиллуулах тухай саналыг холбогдох дээд байгууллагуудад хүргүүлж, "Биеийн тамир, спортын тухай хууль"-д заалт болгож тусгуулсан. Нийслэлийн хэмжээнд хэрэгжилтийг ханган ажиллах ажлын хүрээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар орон тооны арга зүйч ажиллуулахад шаардлагатай орон тоо, цалин хөлс, сургалтын төсвийн тооцооллыг боловсруулж 2026 оны төсөвт тусгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Мөн тус заалтыг Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр тусгуулсан.	70%
1.3.	Нийслэл, дүүргийн хэмжээнд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, биеийн тамир, спортын клуб, өсвөрийн шигшээ багийн багш, дасгалжуулагч, арга зүйч, албан хаагчдад зориулсан сургалтыг зохион байгуулна.	Улсын төсөв 10,040.0	Зохион байгуулсан сургалтын тоо	6	8	Нийслэл, дүүргийн хэмжээнд спортын төрлүүдийг хөгжүүлж, багш, дасгалжуулагчдын ур чадварыг дээшлүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх, туршлага солилцох зорилгоор сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш, арга зүйч, Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багш болон биеийн тамир, спортын клубийн арга зүйч, шүүгчид, сайн дурын ажилтнуудад зориулсан 2025 оны хагас жилийн байдлаар 8 төрлийн сургалт зохион байгуулж 225 байгууллагын 1430 багш, дасгалжуулагч, арга зүйчид,	100%

1	2	3	4	5	6	7	8
						оюутнууд оролцсон.	
1.4.	Төрийн болон аж ахуй нэгж байгууллагын Биеийн тамир, спортын клубын тоог нэмэгдүүлж үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	-	Клубын тоо	815	820	Нийслэлийн хэмжээнд 2025 оны хагас жилийн байдлаар БЗД-ийн 29-р хороо, БЗД-ийн 30-р хороо, БЗД-ийн 31-р хороо, БЗД-ийн 32-р хороо шинээр 4 клуб байгуулж нийт 820 биеийн тамир, спортын хамтлаг үйл ажиллагаагаа тогтмолжуулан ажиллаж байна. Биеийн тамир, спортын хамтлагийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, нийтэд таниулах, урамшуулах зорилгоор Нийслэлийн шилдэг биеийн тамир, спортын клубийн шалгаруулах болзлын дагуу Олон улсын худалдаа логистикийн төв ХК, Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар, Нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын клубүүдийг “Нийслэлийн шилдэг биеийн тамир, спортын клуб”-аар шалгаруулан өргөмжлөл, цом, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.	100%
1.5.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит хүн амын бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг авах ажлыг нийслэлийн хэмжээнд зохион байгуулж нэгдсэн мэдээллийн санд оруулна.	Нийслэлийн төсөв	Нийслэлийн хэмжээнд сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт	74% (А, В, С үнэлгээ авсан байна)	75% (А, В, С үнэлгээ авсан байна)	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийн дагуу бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг Нийслэл, дүүргийн хэмжээнд зохион байгуулж 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 606 байгууллагын 80,792 иргэн хамрагдсан байна. Сорилд хамрагдсан хүмүүсийн: 37 % нь- А, 30 % нь- В, 13 % нь- С, 5 % нь- D, 15 % нь- F үнэлгээ авсан ба нийт 80% нь А,В,С үнэлгээ байна. Сорилд хамрагдсан иргэдийн мэдээлэл, чанарын үзүүлэлтийг	100%

1	2	3	4	5	6	7	8
						www.cpanel.sport.gov.mn сайтад шивж оруулж байна. Одоогоор үр дүн баталгаажих хугацаа болоогүй байна.	
1.6.	Нийтийг хамарсан биеийн тамирын томоохон (Улаанбаатар марафон, Иргэдийн спортын “Хангарди” наадам, Бүжгийн фестиваль, Нийтийн гимнастикийн фестиваль, “Улаанбаатар цом” усанд сэлэлтийн фестиваль, “Алхацгаая-гүйцгээе” хөдөлгөөн гэх мэт) арга хэмжээнүүдийг зохион байгуулна.	Нийслэлийн төсөв Улсын төсөв 34,460.0	Хамрагдсан иргэдийн тоо	888,500	916,978	Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2025 оны эхний хагас жилд нийтийг хамарсан 177 (сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн багш нарын сургалт, хөгжөөн дэмжигчдийн арга хэмжээ, уран хөдөлгөөнт гимнастик, софт, хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил, “Улаанбаатар марафон-2025”, “Алхацгаая гүйцгээе” хөдөлгөөн, олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээ) гэх мэт арга хэмжээ зохион байгуулж 3989 байгууллагын 608,401 иргэдийг хамруулсан	90%
1.7.	Ахмад насны иргэдийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд хамруулж дэмжлэг үзүүлнэ.	-	Хамрагдсан иргэдийн тоо	7042	7394	Нийслэл, дүүргийн хэмжээнд 55-аас дээш насны ахмад иргэдийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах зорилгоор 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийслэл, дүүргийн хэмжээнд 9 спорт зааланд үнэ төлбөргүй тусгай цаг гарган 22 хорооны 390 ахмадыг хичээллүүлж байгаа бол 44 арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулж 833 байгууллагын 6546 ахмадыг хамруулсан. Үүнээс “Улаанбаатар марафон-2025” олон улсын гүйлтийн 1,5км, 5км, 10км, 21км, 42км-ийн зайд 221 байгууллагын 740 ахмадыг	90%

1	2	3	4	5	6	7	8
						хамруулсан байна.	
1.8.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийслэл, дүүргийн хэмжээнд биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулж дэмжлэг үзүүлнэ.	Нийслэл, Улсын төсөв 6,660.0	Оролцогчдын тоо	2400	2520	Нийслэл, дүүргийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 45 арга хэмжээ зохион байгуулж 876 байгууллагын 2295 иргэн хамрагдаад байна. Дээрх арга хэмжээнүүдэд нийт 10.613.100 төгрөгийг зарцуулсан. Үүнээс: Улаанбаатар хотын аварга шалгаруулах хонхтой бөмбөгийн тэмцээнийг 2025 оны 05 дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны спорт зааланд зохион байгуулж, 10 байгууллагын 10 багийн 50 тамирчид оролцож улсын төсвөөс 2,460,000.0 төгрөгийг зарцуулсан бол “Улаанбаатар марафон 2025” олон улсын гүйлтийг 2025 оны 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулж хөгжлийн бэрхшээлтэй болон тусгай хэрэгцээт иргэдийн 7 ангилал (тусгай олимпын төрөл 500 м -т 31 хүн, 800 м -т 39 хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд 1500 м -ийн зайд (хараагүй) 33 хүн, (тэргэнцэртэй) 27 хүн, 21,095 км -т 80 тамирчин, 42,195 км -т 19 тамирчин, гар дугуйн ангилалд 5 тамирчин)-д нийт 229 хүн оролцлоо. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр спорт заал, зориулалтын талбайг нээлттэй, үнэгүй ашиглуулах, секц дугуйланг шинээр	90%

1	2	3	4	5	6	7	8
						байгуулах чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажилласны үр дүнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянгол, Багануур, Багахангай, Налайх, Хан-Уул, 7 дүүргийн биеийн тамир, спортын хороод ашиглалтыг нь хариуцаж байгаа 7 спорт цогцолбор, Баянзүрх, Сүхбаатар дүүргүүд нутаг дэвсгэр дээрээ үйл ажиллагаа явуулж байгаа 14 спорт заал, 3 усан бассейнд үнэ төлбөргүйгээр 7 хоног бүр хуваарьт цаг гарган нийт 32 байгууллагын 1552 иргэнд тогтмол үйлчилгээ үзүүлэн ажиллаж байгаа бол даам, хонхт бөмбөг, бочи, хэрэглэлтэй сэлэм, фитнес, суугаа волейбол, ширээний теннис, туялзуур сэлэм, тусгай олимпын төрөл, пара бадминтон гэсэн 10 төрлөөр секц, дугуйланг хичээллүүлж 23 байгууллагын 220 хүнийг бэлтгэл сургуулилтаар ханган ажиллаж байна.	
1.9.	Нийслэлийн өвлийн спортын 9 арга хэмжээ, 5 төрөл (Цанын бааз, мөсөн гулгуурын талбай, битүү дээвэртэй мөсөн гулгуурын талбай, өдөрлөг, секц дугуйлан)-ийн үйлчилгээг иргэдэд хүргэж ажиллана.	Нийслэлийн төсөв	Зохион байгуулсан ажил	12	14	Өвлийн улиралд иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр 20 удаагийн биеийн тамир, спортын арга хэмжээ, 27 байршилд мөсөн гулгуурын талбай, цанын баазыг байгуулж, биеийн тамир, спортын үйлчилгээг нийт 389,559 иргэдэд хүргэж ажилласан. Үүнд: -Нийслэлийн 9 дүүрэгт нийтийг хамарсан 10 арга хэмжээ зохион байгуулж 26,709 иргэнийг	90%
			Хамрагдсан иргэдийн тоо	425,000	446,335		

1	2	3	4	5	6	7	8
						хамруулсан. -Өвлийн спортын төрлөөр Улаанбаатар хотын аварга шалгаруулах уралдаан, тэмцээнийг 7 удаа зохион байгуулж 693 тамирчин оролцсон. -Дүүргүүдийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багт өвлийн спортын 3 төрөл (хоккей, тэшүүр, шорттрейк)-ийн төрлөөр 95 хүүхэд, багачууд секц, дугуйланд хамрагдаж байна. -Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт байрлах битүү дээвэртэй мөсөн гулгуурын талбайд 2024 оны 01 дүгээр сарын 02-ноос 06 дугаар сарын 10-ны хооронд 103,062 иргэн үйлчлүүлсэн байна. -Сүхбаатар, Баянзүрх, Багануур дүүрэгт Хандгайт, Скай ресорт, Галуут тур, Улаанбаатар цанын баазуудад 153,000 иргэн үйлчлүүлсэн байна. -Орон сууц, гэр хорооллын 22 байршилд мөсөн гулгуурын талбай байгуулагдаж 106,000 иргэдэд үйлчилгээ үзүүлсэн байна.	

Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт 2.

Үндэсний болон орчин үеийн спортын төрлүүдийг хөгжүүлж, нийслэлийн иргэдийн дунд зохион байгуулах уралдаан, тэмцээн наадмын төрлийг нэмж, өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг бэлтгэж суурь үзүүлэлтийг 5 хувиар ахиулна. НХТЖҮЧ-3.5.4, 3.5.5, НЗДҮАХ-2.1.8. НХТ-160, 161, 162, 156.

2.1.	Багийн спортыг дэмжих чиглэлээр өсвөрийн хүүхэд багачуудын дунд “Улаанбаатар лиг” сагсан бөмбөг, волейболын тэмцээн, “Мөрөөдлийн гоол”	Нийслэлийн төсөв	Оролцогчдын тоо	158,746	166,683	Багийн спортын төрлөөр дамжуулан өсвөр үеийн хүүхэд, багачуудын бие бялдрыг чийрэгжүүлэх, хамтач үзэл санааг төлөвшүүлэх зорилгоор 2025 оны эхний хагас жилийн байдлаар “Улаанбаатар лиг” сагсан бөмбөг,	90%
------	--	------------------	-----------------	---------	---------	--	-----

1	2	3	4	5	6	7	8
	хөл бөмбөгийн фестивалийг зохион байгуулна.					волейболын тэмцээнүүдийг зохион байгуулж 8728 багийн 157,746 хүүхэд, залуучуудыг оролцуулж, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/323 дугаар захирамжаар 301,178,000 төгрөгийг зарцуулсан байна.	
2.2.	Спортын холбоодтой 2025 онд хамтран ажиллах гэрээ байгуулан Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг спортын 21 төрлөөр зохион байгуулна.	Улсын төсөв 61,440.0	Тамирчдын тоо	7,888	8,282	Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, спортын холбоодын үйл ажиллагааг дэмжих, спортын төрлийг хөгжүүлэх зорилгоор 2025 оны хагас жилийн байдлаар Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг 16 төрлөөр тухайн спортын холбоотой хамтран зохион байгуулж 423 байгууллагын 6325 тамирчдыг хамруулсан. Шинээр хөгжиж буй спортын төрлүүдийг хөгжүүлэх зорилгоор снөүбоард, виртуал дугуй, шорк трейк төрлийг зохион байгуулж ажилласан.	80%
2.3.	Оюутны шигшээ багийг спортын 8-аас дээш төрлөөр байгуулахад холбогдох бичиг баримтыг боловсруулж, шаардагдах төсвийг 2026 оны төсөвт тусгуулна. /Биеийн тамир, спортын тухай хуулийн 23.6/	-	Хэрэгжилтийн хувь	0	100	Засаг даргын дэргэд оюутны шигшээ баг, дүүргүүдийн Засаг даргын дэргэд өсвөрийн шигшээ багийг шинэчлэн байгуулахад шаардлагатай баримт, бичгүүдийн төслийг боловсруулж, оюутны шигшээ багийн бүтэц бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгууллагын даргын 2025 оны А/14 дүгээр тушаалаар баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус ажлын хэсэг нь "Оюутны шигшээ	70%

1	2	3	4	5	6	7	8
						баг” байгуулах тухай нийслэлийн Засаг даргын захирамжийн төсөл боловсруулах, “Нийслэлийн Засаг даргын дэргэд “Оюутны шигшээ баг” байгуулах, санхүүжүүлэх үйл ажиллагааны журам”-ын төсөл болон “Дүүргүүдийн Засаг дарга нарын дэргэд өсвөрийн шигшээ баг байгуулах, санхүүжүүлэх үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэх ажлыг дүүргүүдийн Биеийн тамир, спортын хороод, спортын холбоодоос санал авч нэгтгэн боловсруулалт хийж байна.	
2.4.	Дүүргүүдийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийг шинэчлэн байгуулж, байнгын дасгал сургалт хийх нөхцөлийг хангаж, өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг бэлтгэнэ.	-	Тамирчдын тоо	3,150	3,307	Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэх, дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж спортын 28 төрөлд 95 багт 95 дасгалжуулагчтай 3060 тамирчдыг бэлтгэл сургуулилтад хамруулж байна. Өсвөрийн шигшээ багийн тамирчид 2025 оны хагас жилийн байдлаар 302 удаагийн тив, дэлхий, олон улс, улс, нийслэл, нэрэмжит тэмцээнд оролцож 1311 медаль авсан амжилт үзүүлсэн байна. Баянзүрх, Хан-Уул, Багануур, Багахангай, Налайх дүүрэг өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг дэмжиж 217,447.5 төгрөгийг зарцуулсан байна	90%
2.5.	Гадаад, дотоодын биеийн тамир, спортын арга	Улсын төсөв 8,400.0	Арга хэмжээний тоо	10	12	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны гадаад арга	70%

1	2	3	4	5	6	7	8
	хэмжээнд оролцуулах, харилцан туршлага судлах ажлыг зохион байгуулна.					хэмжээг 12 ажил үйлчилгээг гүйцэтгэхээр төлөвлөж 2025 оны эхний хагас жилд 6 ажлыг гүйцэтгэсэн. Үүнд: 1."Улаанбаатар марафон-2025" олон улсын гүйлт зохион байгуулж 40 орны 30000 гаруй хүн, 2."Улаанбаатар лиг" сагсан бөмбөгийн ахлах насны ангилалд түрүүлсэн багуудыг ОХУ-ын Москва хотод 2025 оны 09 дүгээр сард болох супер цомын тэмцээн оролцох, 3.БНСУ-ын Гванжү хотын БТСХ-ны дасгалжуулагчтай уулзалт хийсэн, 4.БНСУ-ын Гванжү хотын БТСХ-ны ерөнхийлөгч тэргүүтэй 7 төлөөлөгчийг хүлээн авч санамж бичиг зурагдсан, 5.Тайпэйд болсон Мастеруудын спорт наадамд 50+ сагсан бөмбөгийн баг тамирчид тэмцээнд оролцож алтан медаль хүртсэн. 6.Дэлхийн аварга шалгаруулах 3x3 сагсан бөмбөгийн тэмцээн 2025 оны 06 дугаар сарын 18-21-нд явагдана.	
2.6.	Бүх ард түмний спортын XVI наадам, Хүүхдийн спортын VIII наадмын анхан шатны тэмцээнүүдийг зохион байгуулна.	Нийслэлийн төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	100	Монгол Улсын Засгийн газрын 183 дугаар тогтоолын дагуу 2025 оны эхний хагас жилд Монголын хүүхдийн спортын өвөл, зуны VIII наадмыг зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс 06 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл зохион байгуулж, нийт 40 спортын төрлөөр 6666 тамирчид оролцсон. Монголын хүүхдийн спортын өвлийн наадамд 1-р байранд Баянзүрх	100%

1	2	3	4	5	6	7	8
						дүүрэг, Зуны спортын наадамд: 1-р байранд Хан-Уул дүүрэг, 2-р байранд Сүхбаатар дүүрэг, 3-р байранд Чингэлтэй дүүргийн баг тамирчид тус тус эзэлсэн байна. Дүүргийн Биеийн тамир, спортын хороодыг анхан шатны тэмцээнүүдээ зохион байгуулахад нь удирдлага арга зүйгээр хангаж ажиллаа. Бүх ард түмний спортын XVI наадам дараа улиралд зохион байгуулагдахаар товлосон хугацаа хүлээгдэж байна.	
Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт 3. Нийслэлийн иргэдийн 15 хувь нь оршин суух газраасаа 20 минут алхаж хүрэх зайд ногоон байгууламж бүхий спортын цогцолборыг бий болгох, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцлийг сайжруулж, спортын барилга, байгууламжийн хүртээмжийг 1000 хүнд 70 м2-д хүргэж нэмэгдүүлнэ. НХТЖҮЧ-3.5.2, НЗДҮАХ-2.1.9, НХТ-157, 158, 159							
3.1.	Сонгинохайрхан дүүргийн өвлийн спортын ордон, Баянзүрх, Багахангай дүүргийн спорт цогцолборын барилгын ажлыг үргэлжлүүлнэ.	Улсын төсөв 5,526,400.0	Гүйцэтгэлийн хувь	55	70	Улсын төсвөөр баригдаж байгаа Багахангай, Баянзүрх дүүргийн спорт цогцолбор, Сонгинохайрхан дүүргийн өвлийн спортын ордон, усан спортын төвийн барилгын явцын биелэлтийг холбогдох байгууллагуудаас цаг тухай бүр авч бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан заалт тус бүрээр биелэлтийг гаргаж байгууллагын удирдлага болон дээд шатны байгууллагуудыг мэдээллээр ханган ажиллаж байна. Үүнд: Сонгинохайрхан дүүргийн 34-р хороонд баригдаж байгаа усан спортын төвийн барилга баригдаж дууссан бөгөөд улсын комисст өгөх ажил хүлээгдэж байна. Баянзүрх дүүргийн спорт цогцолбор 85	70%

1	2	3	4	5	6	7	8
						хувьтай, Багахангай дүүргийн спорт цогцолбор 80 хувьтай, Сонгинохайрхан дүүргийн 20-р хороонд баригдаж байгаа өвлийн ордон 30 хувьтай, Хан-Уул дүүргийн Оюуны спортын ордон 90 хувьтай баригдаж байгаа бөгөөд нийт ажлуудын гүйцэтгэл 65 хувьтай хэрэгжиж байна.	
3.2.	Баянхошуу дэд төвийн спортын цогцолборын барилгын ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж ашиглалтад оруулна.	Азийн хөгжлийн сан 3,000,000.0 Нийслэлийн төсөв	Гүйцэтгэлийн хувь	70	100	Азийн хөгжлийн банкны 60 хувь, нийслэлийн төсвийн 40 хувийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа Баянхошуу дэд төвийн спорт цогцолбор 75 хувьтай үргэлжилж байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар дотор засал болон гадна тохижилтын ажил хийгдэж байна. Мөн усан бассейны түргэн тусламж үзүүлэх эмнэлгийн багаж, төхөөрөмжийн худалдан авалт хийгдээд байна.	70%
3.3.	Биеийн тамир, спортын талбайн бүтээн байгуулалт, тохижилтыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	-	Бүтээн байгуулсан, тохижуулсан талбайн тоо (өссөн дүнгээр)	203	223	2025 оны эхний хагас жилийн байдлаар Сонгинохайрхан дүүргийн 21-р хороо, Жаргалант тосгонд 3х3 сагсан бөмбөгийн талбай шинээр байгуулагдсан бол 3 байршилд 3х3 сагсан бөмбөгийн талбайг хувийн аж ахуй нэгж байгууллагуудаас шинэчлэн тохижуулж нийт 207 талбай болсон. Мөн Сонгинохайрхан дүүргийн 3-р хороонд хөл бөмбөгийн хиймэл зүлэг бүхий спортын иж бүрэн талбайн ажил 95 хувьтай, ЧД 24-р хороо, лагерийн бүсэд байрлах “Зуун мод” цэцэрлэгт хүрээлэнг иргэд, хүүхэд залуучуудын амарч,	70%

1	2	3	4	5	6	7	8
						чөлөөт цагаа өнгөрөөх шинэ ногоон орчин болгон тохижуулах ажил 80 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.	
3.4.	Нийслэлд спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.	-	Спортын барилга байгууламжийн хүртээмж (м2)	65	66	Спортын барилга байгууламжийн хүртээмж 2024 оны жилийн эцсийн байдлаар 1000 хүнд 65 м2-д хүрснийг тодорхойлж гаргасан. 2025 оны эхний хагас жилийн байдлаар улсын төсвөөр баригдаж байгаа Багахангай, Баянзүрх дүүргийн спорт цогцолбор, Сонгинохайрхан дүүргийн өвлийн спортын ордон, усан спортын төвийн барилгын явцын биелэлтийг холбогдох байгууллагуудаас цаг тухай бүр авч бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан заалт тус бүрээр биелэлтийг гаргаж байгууллагын удирдлага болон дээд шатны байгууллагуудыг мэдээллээр ханган ажиллаж байна. Үүнд: Сонгинохайрхан дүүргийн 34-р хороонд баригдаж байгаа усан спортын төвийн барилга баригдаж дууссан бөгөөд улсын комисст өгөх ажил хүлээгдэж байна. Баянзүрх дүүргийн спорт цогцолбор 85 хувьтай, Багахангай дүүргийн спорт цогцолбор 80 хувьтай, Сонгинохайрхан дүүргийн 20-р хороонд баригдаж байгаа өвлийн ордон 30 хувьтай, Хан-Уул дүүргийн Оюуны спортын ордон 90 хувьтай баригдаж байгаа бөгөөд нийт ажлуудын гүйцэтгэл 65 хувьтай, Азийн хөгжлийн банкны 60 хувь,	70%

1	2	3	4	5	6	7	8
						нийслэлийн төсвийн 40 хувийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа Баянхошуу дэд төвийн спорт цогцолбор 75 хувьтай үргэлжилж байна. Спортын барилга байгууламжийн хүртээмжийг жилийн сүүлийн улиралд хийхээр төлөвлөн ажиллаж байна.	

Зорилт 4.

Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт

4.1.	Улс, нийслэл, байгууллагын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүд, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, бусад холбогдох баримт бичгүүдэд санал боловсруулан хүргүүлж ажиллана.	-	Санал өгсөн баримт бичгүүдийн тоо	12	12	2025 оны эхний хагас жилийн байдлаар бодлогын баримт бичиг нийт 5 удаа санал боловсруулан албан тоотоор холбогдох байгууллагуудад хүргүүлж ажиллаа. Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, байгууллагын чиг үүргийн дагуу тусгах ажлын саналыг боловсруулан тайлбар, танилцуулгын хамт холбогдох байгууллагуудад хүргүүлж тусгуулж ажилласан.	70%
4.2.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тайлан, мэдээг нэгтгэн	-	Хугацаа хоцроосон тайлан мэдээний тоо	Хугацаа хэтэрч явуулсан тайлан мэдээний тоо 0	Хугацаа хэтэрч явуулсан тайлан мэдээний тоо 0	Нийслэлийн Биеийн тамир, спортын газар нь 2025 оны эхний хагас жилийн байдлаар 15 тайлан, мэдээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүд, дотоод	90%

1	2	3	4	5	6	7	8
	холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.					удирдлагын нэгдсэн программ ERP-н хяналт шинжилгээ, үнэлгээ дэд системд оруулж ажилласан бөгөөд хугацаа хэтэрч явуулсан тайлан, мэдээ гараагүй байна. 2025 оны эхний хагас жилд 19 тайлан, мэдээг гаргахаар төлөвлөснөөс хугацаа болж тайлагнасан 15, боловсруулалт хийгдэж байгаа 4 тайланг хугацаанд нь явуулахаар бэлтгэж байна.	
4.3.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн төлөвлөгөөнд манай байгууллагад хариуцуулан тусгасан үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	-	Хяналт, шинжилгээ үнэлгээ хийсэн тайлангийн тоо	10	10	Бодлогын баримт бичигт хяналт шинжилгээ, үнэлгээ хийх 12 ажил бүхий төлөвлөгөөг байгууллагын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, захиргааны байгууллагын үйл ажиллагааны 12 /давхардсан тоогоор/ тайлан, мэдээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр төлөвлөн явцын хяналт-шинжилгээг 4 тайланд хийсэн бөгөөд боловсруулалт хийгдэж байгаа 8 тайлан байна.	100%
4.4.	Байгууллагын албан хаагчдын шилжилт хөдөлгөөний мэдээг төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн удирдлагын системд оруулна.	-	Шинэчилсэн мэдээллийн тоо	14	15	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 84, 238 дугаар тогтоолоор албан хаагчдын цалин хөлс, албан тушаалын ангилал, шатлал, зэрэглэл болон цалин хөлс тооцоолоход шаардагдах өөрчлөлтүүдийг 2 удаа давхардсан тоогоор 16 албан хаагчийн мэдээллийг төрийн албаны зөвлөлийн "Хүний нөөцийн	100%

1	2	3	4	5	6	7	8
						удирдлагын систем"-д шинэчилж оруулсан. Мөн байгууллагын 16 албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг төрийн албаны зөвлөлийн "Хүний нөөцийн удирдлагын систем"-д оруулж баталгаажуулсан байна.	
4.5.	Биеийн тамир, спортын салбарын байгууллагуудын статистик судалгааны дүн мэдээг шинэчилж нэгтгэн цахим программд оруулна.	-	Цахим програмд оруулсан мэдээний тоо	7	7	Биеийн тамир, спортын төрийн байгууллагын үйл ажиллагааны 2024 оны 7 төрлийн мэдээг Үндэсний Статистикийн газрын 3-БТС-1, А-БТС-6, А-БТС-7 маягтын дагуу бэлтгэн https://cpanel.sport.gov.mn/ программд оруулж pdf хэлбэрээр 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Биеийн тамир, спортын Улсын хорооны www.info@sport.gov.mn албан ёсны цахим хаягаар хүргүүлсэн.	100%
4.6.	Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг тайлагнах, ХАСХОМ гаргах албан хаагчдыг хуулийн хугацаанд мэдүүлэх ажлыг зохион байгуулна.	-	Хэрэгжилтийн хувь	100	100	Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ХАСХОМ гаргах албан хаагчдад зориулсан зохион байгуулсан 2 удаагийн сургалтад давхардсан тоогоор 37 албан хаагчийг хамруулсан. ХАСХОМ-ийг мэдүүлэх нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын газар, хороодын 41 албан хаагчид хуулийн хугацаанд мэдүүлгийг гарган баталгаажуулж, мэдээллийг Биеийн тамир, спортын улсын хороонд хүргүүлж ажиллаа. Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, холбогдох	100%

1	2	3	4	5	6	7	8
						дээд байгууллагуудад хүргүүлсэн бөгөөд эхний хагас жилийн тайланг 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр гаргаж хүргүүлэхээр нэгтгэж байна.	
4.7.	Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороог шинэчлэн батлаж ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Хэрэгжилтийн хувь	100	100	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын Ёс зүйн дэд хороог 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр хамт олны хурлаар хэлэлцэн санал хурааж 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан байгууллагын даргын 2025 оны А/13 тушаалаар батлуулж, 2025 оны Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөг байгууллагын даргаар батлуулан хагас, бүтэн жилээр хэрэгжилтийг тайлагнан ажиллахаар төлөвлөсөн. 2025 оны эхний хагас жилийн байдлаар Ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй бөгөөд иргэд, аж, ахуйн нэгж байгууллагаас албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл ирээгүй байна.	100%
4.8.	Нийслэлийн 2025 оны төсөвт батлагдсан байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, өр, авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнана.	Нийслэлийн төсөв 8,838.7	Хэрэгжилтийн хувь	100	100	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын байр ашиглалтын зардалд 2025 онд 8,838,700 (найман сая найман зуун гучин долоон мянган) төгрөг батлагдсан бөгөөд 2024 оны эхний хагас жилд 4,419,600 (дөрвөн сая дөрвөн зуун арван есөн мянга зургаан зуун) төгрөгийн санхүүжилт авч 2,736,00 (хоёр сая долоон зуун гучин зургаан мянган) төгрөгийг зарцуулан, өр авлага үүсгэлгүй ажиллаж сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайланг хугацаанд нь	100%

1	2	3	4	5	6	7	8
						хүргүүлж ажилласан.	
4.9.	Нийслэлийн Засаг даргыг шүүхэд итгэмжлэлээр төлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу оролцох, үр дагаврыг нийслэлийн Засаг даргын өмнө бүрэн хариуцна.	-	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь	100	100	2025 оны эхний хагас жилийн байдлаар биеийн тамир, спортын чиглэлээр гарсан шүүхийн маргаан байхгүй байна.	100%
4.10	Өөрийн эрхлэх чиг үүргийн хүрээнд салбарын хууль тогтоомж болон бусад хууль, тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулж холбогдох байгууллагуудад хүргүүлнэ	-	Хүргүүлсэн саналын тоо	1	1	Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 01 дүгээр албан даалгавраар өгөгдсөн үүрэг чиглэлийн дагуу Биеийн тамир, спортын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэхэд “дүүргийн хороодод орон тооны арга зүйч” ажиллуулах саналтай холбоотой мэдээллийг шуурхай өгч ажиллахаар чиглэл авч ажиллаж байна. Нийслэлийн нутаг дэвсгэр дэх аж ахуй, нэгж, байгууллага хороо тус бүрд “Биеийн тамир, спортын хамтлаг” байгуулах журмыг шинэчлэхээр боловсруулалт хийгдэж байна.	100%
4.11	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.	-	Хэрэгжүүлсэн ажлын тоо	11	12	Нийслэлийн Биеийн тамир, спортын Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2025 оны эхний хагас жилд арга хэмжээ (Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Улаанбаатар лиг” сагсан бөмбөгийн техникийн зөвлөгөөн, Цэцэрлэгийн хүүхдүүдийн Уран хөдөлгөөнт	100%

1	2	3	4	5	6	7	8
						гимнастикийн тэмцээнүүдийн техникийн зөвлөгөөн, Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багш, арга зүйчдийг чадавхжуулах сургалт, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын биеийн тамирын багш, арга зүйчдэд зориулсан чадавхжуулах сургалт, Хөгжөөн дэмжигчдийн сургалт, "Улаанбаатар марафон-2025" олон улсын гүйлтийн техникийн зөвлөгөөн) зохион байгуулахад оролцсон нийт 416 багийн 1076 багш, арга зүйчдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 17 дугаар зүйл, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.3, 9.9 дэх заалт, Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хэм хэмжээг танилцуулж, мэдээллээр хангаж ажилласан.	
4.12	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Хэрэгжүүлсэн ажлын тоо	11	11	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 6 үйл ажиллагаа хэрэгжүүлэх төлөвлөгөө байгууллагын даргаар батлуулж, хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан бөгөөд "Харилцан хүндэтгэе" нэг сарын аянд нэгдэж 6 ажил зохион байгуулсан.	70%
4.13	Биеийн тамир, спортын чиглэлээр шинээр боловсруулах, шинэчлэх шаардлагатай стандарт,	-	Сурталчилж ажилласан ажлын тоо, хүртээмж	4 ажил, 1230 хүн	5 ажил, 1250 хүн	Биеийн тамир, спортын салбарын хэмжээнд мөрдөгдөж буй 19 стандарт болон хотын хэмжээнд батлагдсан 52 стандартыг 3	70%

1	2	3	4	5	6	7	8
	нормд санал өгөх, сурталчилан хэрэгжүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.					удаагийн сургалтын хөтөлбөрт тусган зохион байгуулж 120 байгууллагын 680 хүнийг мэдээллээр хангаж ажиллаа. Үүнд: Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2025 оны 01 дүгээр сарын 30-аас 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулсан сургуулийн ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багш нарын сургалтад 9 дүүргийн 80 ерөнхий боловсролын 130 биеийн тамирын багш нар хамрагдсан бол “Улаанбаатар марафон 2025” олон улсын гүйлтийн шүүгч, сайн дурын ажилтанд чиглэл өгөх 2 удаагийн сургалтад 40 байгууллагын 550 ажилтан хамрагдсан.	
Зорилт 5. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт:							
5.1.	Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмыг шаардлагын дагуу хангаж ажиллана.	-	Хэрэгжүүлсэн чиг үүргийн тоо	6	8	Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын эхний хагас жилд 6 чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан. Үүнд: Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гарган батлуулж, 2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу мэргэжилтэн тус бүрээс архивын баримт хүлээн авах хуваарь гаргаж хуваарийн дагуу байгууллагын архивд баримтыг 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар байнга хадгалах 18, 70 жил хадгалах 2, түр хадгалах 77, дүрс бичлэг 1 нийт 98 хадгаламжийн нэгжийг архивлаж хүлээн авсан. Нийслэлийн Засаг даргын 2013 оны	100%

1	2	3	4	5	6	7	8
						А/452 дугаар захирамжаар батлагдсан “Захирамжлал (захирамж, тогтоол, тушаал)-ын баримтад цахим хувь үйлдэх ажлын удирдамж”-ийн 1.7, 1.8 дахь хэсэгт заасны дагуу 2024 онд үүсэж хөтлөгдсөн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гаргасан А/52, хүний нөөцийн чиглэлээр гаргасан Б/26 тушаалыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын нэгдсэн программ (arch.ulaanbaatar.mn) системд захирамжлалын баримтаа цахим хэлбэрт шилжүүлж, нийслэлийн Архивын газарт актаар хүлээлцсэн. Архивын баримтыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/222 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 13.3-т заасны дагуу тус оны баримтын данс, бүртгэл, устгах баримтын жагсаалтыг нийслэлийн Архивын газрын дэргэдэх баримт шалгах арга зүйн комиссоор хэлэлцүүлэн батлуулж, 2025 оны 06 дугаар сарын 10-ны байнгын 198, захирамжлалын 16, дүрс бичлэг 21 хадгаламжийн нэгжийг төрийн архивд хүлээлгэн өгсөн.	

1	2	3	4	5	6	7	8
5.2.	Байгууллагын хэмжээнд дотоод төлөвлөгөө хэрэгжилтийг хангана.	-	Дотоод хяналт шалгалт хийсэн ажлын тоо	4	2	Байгууллагын хэмжээнд дотоод хяналтын ажлын төлөвлөгөөг 9 үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөг байгууллагын даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж 2025 оны эхний хагас жилийн дотоод хяналт шалгалтыг 06 дугаар сарын 20-нд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.	100%
